



# АУДИТЫН ТАЙЛАН

Орон тоо дутуу ажилласнаас болон аймаг, сумдын ОНХО, ОНХС-аар хэрэгжүүлэх арга хэмжээ дутуу хэрэгжсэнээс голлон шалтгаалж төсвийн гүйцэтгэл 81.0 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

## АУДИТЫН СЭДЭВ: СЭЛЭНГЭ АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Аудитын код: СЭА-2025/01-НА-СТА-ТЕЗ

|   |   |
|---|---|
| Цахим хуудас:<br><a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a><br>Сүхбаатар сум<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа<br>Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a><br>Аудитын менежер: Б.Батмөнх<br>Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a><br>Ахлах аудитор: Ц.Отгонбаяр<br>Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayarts@audit.gov.mn">otgonbayarts@audit.gov.mn</a> |
|---|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Тайланг бэлтгэсэн:**

|   |  |    |
|---|--|----|
| <b>Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар</b>  | Агуулга  | 1  |
|   | Товчилсон үгийн жагсаалт   | 2  |
|   | Нэг.Ерөнхий зүйл   | 3  |
| <b>Дарга, тэргүүлэх аудитор</b>   | <b>ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ</b>   | 4  |
| <b>Ч. Энхтуяа</b>   | <b>БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?</b>   |    |
| <b>Аудитын менежер</b>  | 1.1 Орон нутгийн төсвийн орлогыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?                    | 5  |
| <b>Б. Батмөнх</b>   | 1.2 Орон нутгийн төсвийн зарлагыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн, үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?                  | 7  |
| <b>Ахлах аудитор</b>  | 1.3 Төсвийн жилийн дундуур төсөвт тодотгол хийгдсэн эсэх?  | 10 |
| <b>Ц.Отгонбаяр</b>  |  |    |
| <b>2025 оны 04 дүгээр сар</b>   | <b>БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛСЭН ҮҮ?</b>  |    |
| <b>Уг тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү:</b>  | 2.1 Татварын ба татварын бус орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн ашигласан эсэх?                                      | 12 |
| <b>www.open.audit.mn</b>  | 2.2. Төсөвт байгууллагуудын төлөвлөсөн өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж, нэмэгдүүлэх нөөц боломжийг ашигласан эсэх?         | 14 |
| <b>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70362442, 70363036 дугаарын утас, <a href="mailto:selenge@audit.gov.mn">selenge@audit.gov.mn</a> хаягаар харилцана уу.</b> | <b>БҮЛЭГ 3. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ, ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛСАН УУ?</b>   |    |
|   | 3.1 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл, түүний хэтрэлт хэмнэлтийн шалтгаан бодитой, үнэн зөв эсэх?                    | 16 |
|   | 3.2 Батлагдсан төсвийг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, зориулалтын дагуу зарцуулсан эсэх?                           | 18 |
|   | 3.3 ОНХО болон ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн эсэх? | 20 |
|   | 3.4 Шилэн дансны болон Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт үр нөлөөтэй байна уу ?  | 22 |
| <b>ХАЯГ:</b>  |  |    |
| <b><u>Сэлэнгэ аймаг дахь төрийн аудитын газар</u></b>   |  |    |
| <b>Аймгийн ЗДТГ-ын байр, Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг-43080</b>   |  |    |
| <b>Монгол Улс</b>   |  |    |
|   | <b>ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ</b>  | 23 |
|   | <b>АУДИТЫН ДҮГНЭЛТ</b>   | 23 |
|   | <b>ЗӨВЛӨМЖ</b>   | 24 |

## Товчилсон үгийн жагсаалт

|             |   |
|-------------|---|
| ААН         | Аж ахуйн нэгж   |
| ААНОАТ      | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар   |
| БОГ         | Байгаль орчны газар   |
| ЗДНХ        | Засаг даргын нөөц хөрөнгө   |
| ЗДТГ        | Засаг даргын Тамгын газар   |
| ИТХ         | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал  |
| НДШ         | Нийгмийн даатгалын шимтгэл  |
| НҮТББ       | Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага  |
| ОНӨААТҮГ    | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар                                  |
| ОНӨГ        | Орон нутгийн өмчийн газар   |
| ОНХНС       | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан   |
| ОНХО        | Орон нутгийн хөрөнгө оруулалт   |
| ОНХС        | Орон нутгийн хөгжлийн сан   |
| СТСХ        | Санхүү төрийн сангийн хэлтэс  |
| ТБОНӨХБАУХА | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай |
| ТЕЗ         | Төсвийн ерөнхийлөн захирагч   |
| УИХ         | Улсын Их Хурал  |
| ҮХЭХАТ      | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар   |
| ХХС         | Хоршоо хөгжүүлэх сан  |
| ХААГ        | Худалдан авах ажиллагааны газар   |
| ХХК         | Хязгаарлагдмал хариуцлагатай компани  |
| ХХОАТ       | Хувь хүний орлогын албан татвар   |

## **Нэг. Ерөнхий зүйл**

### **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

#### **1. Аудитын нэр:**

Сэлэнгэ аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэл

#### **2. Аудитын код:**

СЭА-2025/01-НА-СТА-ТЕЗ

#### **3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:**

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

#### **4. Аудитын зорилт:**

Сэлэнгэ аймгийн 2024 оны төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжүүлсэн эсэх, гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг шалган, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- *Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн үү?*
- *Орон нутгийн төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн үү ?*
- *Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулсан уу?*
- *Шилэн дансны тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангасан уу ?*

#### **5. Аудитын хамрах хүрээ:**

Аудитыг Сэлэнгэ аймгийн ИТХ-аас баталсан 2024 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээ, тайлан, жилийн эцсийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтууд, холбогдох судалгаа болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

#### **6. Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын тулгуур зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аймаг, сумдын ЗДТГ, аймгийн Татварын газрын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, худалдан авалт, санхүүжилттэй холбоотой

баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

## **7. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:**

Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль, Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан “Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль”-д оруулсан нэмэлт өөрчлөлт, Татварын багц хуулиуд, Сангийн сайдын 2021 оны 239, 2023 оны 119 дүгээр тушаал, , аймгийн ИТХ-ын “Төсөв батлах тухай” 2023 оны 142, 2024 оны 180 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/639, 2024 оны А/102, А/278, А/461 дүгээр захирамжууд, ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

## **8. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:**

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, үе шатны, чанарын хяналтыг аудитын менежер Б.Батмөнх гүйцэтгэн, ахлах аудитор Т.Болор, Ц.Отгонбаяр, аудитор О. Анхбаяр, Б.Наранцэцэг, Ж.Баясгалан, Э.Энхбүрэн нар 2025 оны 03 дугаар сарын 25-аас 04 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

## **ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

Сэлэнгэ аймгийн 2024 оны төсвийн орлого нь татварын ба татварын бус орлого, улсын төсвийн орлогын шилжүүлэг, ОНХНС-ийн шилжүүлэг, сумдад олгох санхүүгийн дэмжлэг, сумдаас авах татаас, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоос бүрдсэн бөгөөд уг эх үүсвэрээр орон нутгийн төсвийн 106 байгууллагын урсгал зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ болон ОНХС, Хоршоог хөгжүүлэх сан / ХХС /зэрэг тусгай сангуудыг санхүүжүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 82 дугаар тогтоолоор 2024 оны төсвийн орлогыг **66,560.8** сая төгрөгөөр, зарлагыг **65,197.5** сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг **1,363.3** сая төгрөгөөр тус тус төлөвлөж, баталсан байна.

Улсын төсөвт тодотгол хийсний улмаас аймаг, сумдын төсөвт тус бүр 1 удаа тодотгол хийж, аймгийн төсвийг **45,133.5** сая төгрөгөөр, сумдын төсвийг **90,394.9** сая төгрөгөөр, нийт төсвийг **135,528.4** сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 3,937.4 сая төгрөгөөр тасарч, сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 4,138.4 сая төгрөгөөр давж биелснээр нийт төсвийн орлогын төлөвлөгөө 201.0 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар давж биелсэн байна.

Сэлэнгэ аймгийн 2024 оны төсвийн зарлага / аймаг, сумд нийлсэн дүн /-ыг **135,528.4** сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр **109,717.0** сая төгрөг зарцуулж, 81.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

## **БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?**

### **1.1 Орон нутгийн төсвийн орлогыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?**

*Аймгийн ТЕЗ нь сумдын суурь орлогод малын тоо толгойн албан татвар болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг оруулан тооцсон байна*

**1.1.1** Төсвийн тухай хуулийн 57, 58 дугаар зүйлийн 58.2-д заасан нөхцөл, чиг үүрэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", аймгийн 2024 оны төсвийн төсөл, холбогдох бусад хууль эрх зүйн актуудыг үндэслэн Сэлэнгэ аймгийн 2024 оны төсвийн орлогыг төлөвлөсөн байна.

**1.1.2** УИХ-аас Сэлэнгэ аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг 21,509.0 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 26,529.0 сая төгрөгөөр, сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 4,392.7 сая төгрөгөөр зэрэг нийт **52,430.7** сая төгрөгийн орлого бүрдүүлж, улсын төсөвт **1,363.3** сая төгрөгийг төвлөрүүлэн **51,067.4** сая төгрөгийг зарцуулахаар баталж, ирүүлжээ.

**1.1.3** Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 142 дугаар тогтоолоор дээрх орлогыг 14,130.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, **66,560.8** сая төгрөгөөр /Хавсралт 1-д дэлгэрэнгүйгээр харуулав/ баталсан байна. Үүнд:

- *Татварын болон татварын бус орлогыг 8,429.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 29,938.9 сая төгрөгөөр,*
- *Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 2,725.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 7,118.4 сая төгрөгөөр,*
- *ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 26,529.0 сая төгрөгөөр,*
- *Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 47.0 сая төгрөгөөр,*
- *ОНХС-ийн урьд оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 1,398.2 сая төгрөгөөр,*
- *Ерөнхий орлогын дансны урьд оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 1,529.3 сая төгрөгөөр гэх зэрэг.*

**1.1.4** Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлж, ИТХ-аар батлуулсан төсөвт төсвийн үнэн зөв байдлыг хангаагүй дараах **3,409.0** сая төгрөгийн зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.2: төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;" 23 дугаар зүйлийн 23.6 дахь "Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ, 23.6.5: "Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр," 60 дугаар зүйлийн 60.2.8, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар

баталсан “ Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.6<sup>1</sup> дахь заалтуудыг тус тус зэрчсэн байна. Үүнд:

- Бүх сумдын малын тоо толгой албан татварын 2,837.4 сая төгрөгийг суурь орлогод оруулж тооцсон,
- Аймгийн төсвийн орлогод тооцогдохоор зохицуулагдсан үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн 553.8 сая төгрөгийг Ерөө, Мандал, Хүдэр, Жавхлант, Орхонтуул, Сайхан, Түшиг зэрэг нийт 7 сумын суурь орлогод оруулж, тооцсон,
- Сант сумын үл хөдлөх хөрөнгийн албан татварын сүүлийн 3 жилийн гүйцэтгэл дунджаар 2.0 сая төгрөг байхад, орон андуурч 20.0 сая төгрөгөөр тооцсон гэх мэт.

**1.1.5** Сумдын суурь орлогыг үнэн зөв тооцоогүйгээс шалтгаалан аймгийн төсвөөс сумдын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг багаар батлагдаж, сумдууд зардлаа нөхөхийн тулд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг үндэслэлгүйгээр өндрөөр төлөвлөсөн байна.

**1.1.6** 2024 оны 12 дугаар сард хуралдсан сумдын ИТХ-аар 2024 оны төсвийн хянагдсан суурь орлогыг тус бүр 114.0-4,515.2 сая төгрөгөөр буюу нийт **18,109.9** сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Хүснэгт №1. Сумдын төсвийн орлогын төлөвлөлт

/сая төгрөг/

| №           | Сумд        | Өмнөх оны гүйцэтгэл | Хянасан суурь орлого | Баталсан орлого | Орлогын зөрүү   |
|-------------|-------------|---------------------|----------------------|-----------------|-----------------|
| 1           | Алтанбулаг  | 692.9               | 534.2                | 798.1           | 263.9           |
| 2           | Баруунбүрэн | 668.0               | 522.9                | 675.7           | 152.8           |
| 3           | Баянгол     | 1,965.2             | 1,438.7              | 2,007.4         | 568.7           |
| 4           | Ерөө        | 7,490.9             | 4,560.9              | 9,076.1         | 4,515.2         |
| 5           | Жавхлант    | 409.2               | 404.9                | 518.9           | 114.0           |
| 6           | Зүүнбүрэн   | 669.0               | 440.3                | 936.2           | 495.9           |
| 7           | Мандал      | 9,093.6             | 6,382.0              | 9,842.2         | 3,460.2         |
| 8           | Орхон       | 602.9               | 404.9                | 716.1           | 311.2           |
| 9           | Орхонтуул   | 690.5               | 508.8                | 1,053.8         | 545.0           |
| 10          | Сайхан      | 4,022.4             | 3,579.5              | 4,862.8         | 1,283.3         |
| 11          | Сант        | 488.4               | 310.3                | 457.9           | 147.6           |
| 12          | Сүхбаатар   | 9,317.7             | 9,458.0              | 11,704.2        | 2,246.2         |
| 13          | Түшиг       | 895.6               | 290.6                | 695.2           | 404.6           |
| 14          | Хушаат      | 541.9               | 384.9                | 531.2           | 146.3           |
| 15          | Хүдэр       | 3,187.9             | 404.9                | 2,995.4         | 2,590.5         |
| 16          | Цагааннуур  | 1,803.4             | 1,163.2              | 1,871.1         | 707.9           |
| 17          | Шаамар      | 869.7               | 750.2                | 906.8           | 156.6           |
| <b>НИЙТ</b> |             | <b>43,409.2</b>     | <b>31,539.2</b>      | <b>49,649.1</b> | <b>18,109.9</b> |

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын төсөв баталсан тогтоолууд

<sup>1</sup> ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй:4.6.1.Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгийг энэхүү журмын 4.5-д заасан зорилгоор;

**1.1.7** Дараах сумдууд татварын болон татварын бус орлогын хянагдсан төсвийг өөрийн нөөц боломжид тулгуурлан тооцож, нэмэгдүүлж баталсныг орлогын нэр төрлөөр нь авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Ерөө сум ХХОАТ-ын орлогыг 4,136.0 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 99.6 сая төгрөгөөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 228.0 сая төгрөгөөр,
- Мандал сум ХХОАТ-ын орлогыг 2,554.4 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлогыг 140.0 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 200.3 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогыг 89.8 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 150.5 сая төгрөгөөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 56.8 сая төгрөгөөр,
- Хүдэр сум ХХОАТ-ын орлогыг 412.0 сая төгрөгөөр, дуудлага худалдааны орлогыг 232.0 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 1,208.6 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 777.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, малын тоо толгойн албан татварыг 148.0 сая төгрөгөөр бууруулан нийт дүнгээр 2,482.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- Сүхбаатар сум ХХОАТ-ын орлогыг 2,166.2 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 80.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- Сайхан сум ХХОАТ-ын орлогыг 725.4 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлогыг 34.1 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 141.2 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогыг 74.1 сая төгрөгөөр, ҮХЭХАТ-ын орлогыг 225.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

**1.2. Орон нутгийн төсвийн зарлагыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн, үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?**

*Аймаг, сумдууд нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнүүдийг ОНХО болон ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна*

**1.2.1** Аймгийн ИТХ-ын 2023 оны 142 дугаар тогтоолоор 2024 оны аймгийн хянагдсан төсвийн нийт зарлагыг 14,130.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, **66,560.8** сая төгрөгөөр /Хавсралт 2-т дэлгэрэнгүйгээр харуулав/ төлөвлөж, баталсан байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын зардлыг 745.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,710.9 сая төгрөгөөр,
- Аймгийн ЗДТГ-ын зардлыг 1,174.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 6,345.2 сая төгрөгөөр,
- ЗДНХ-ийн зардлыг 559.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,055.3 сая төгрөгөөр,
- БОАЖГ-ын зардлыг 1,440.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 3,530.2 сая төгрөгөөр,
- Санхүүгийн хяналт аудитын албаны зардлыг 120.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 456.8 сая төгрөгөөр,
- ХААГ-ын зардлыг 372.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 394.4 сая төгрөгөөр,
- ОНӨГ-ын зардлыг 333.8 сая төгрөгөөр,
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 788.0 сая төгрөгөөр,
- Улсын төсвийн байгууллагуудын төрийн албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийг 1,149.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,449.0 сая төгрөгөөр,
- Засаг даргын ерөнхий дансны бусад зардлыг 27.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 891.8 сая төгрөгөөр,

- Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлыг 473.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2,378.4 сая төгрөгөөр,
- ОНХО-ын зардлыг 1,266.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 6,468.3 сая төгрөгөөр,
- Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 4,613.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 11,468.2 сая төгрөгөөр,
- ОНХС-ийн зарцуулалтыг улсын төсвөөс 26,529.0 сая төгрөгөөр хянаж ирүүлснийг өмнөх оны үлдэгдэл 1,398.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 27,927.2 сая төгрөгөөр,
- Улсын төсөвт төвлөрүүлэх зардлыг 1,363.3 сая төгрөгөөр гэх зэрэг.

**1.2.2** Аймгийн ИТХ-ын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 132 дугаар тогтоолоор “**Сэлэнгэ аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө**”-г 8 зорилт, 137 арга хэмжээтэйгээр баталсан байна.

**1.2.3** Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “**Орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх**” гэж зохицуулсан байдаг.

**1.2.4** Гэвч аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан нийт 68 төсөл арга хэмжээний 3,067.1 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 29 төсөл, арга хэмжээ буюу нийт шинээр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний **42.5** хувь нь хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй бол аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн 788.0 сая төгрөгийн зардлыг уг төлөвлөгөөтэй уялдуулалгүйгээр бөөн дүнгээр төлөвлөж, баталсан байна.

**1.2.5** Сумдын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сард хуралдсан хуралдаануудаар 2024 оны төсвийн нийт зарлагыг нийт **86,901.8** сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №2. Сумдын төсвийн зарлагын төлөвлөлт

| /сая төгрөг/ |             |                  |
|--------------|-------------|------------------|
| №            | Сумд        | Баталсан зарлага |
| 1            | Алтанбулаг  | 2,398.5          |
| 2            | Баруунбүрэн | 2,753.2          |
| 3            | Баянгол     | 4,579.4          |
| 4            | Ерөө        | 12,256.5         |
| 5            | Жавхлант    | 2,208.1          |
| 6            | Зүүнбүрэн   | 2,667.0          |
| 7            | Мандал      | 14,847.1         |
| 8            | Орхон       | 2,010.7          |
| 9            | Орхонтуул   | 4,345.1          |
| 10           | Сайхан      | 6,838.9          |
| 11           | Сант        | 2,287.9          |
| 12           | Сүхбаатар   | 12,374.3         |
| 13           | Түшиг       | 3,579.4          |
| 14           | Хушаат      | 2,411.7          |
| 15           | Хүдэр       | 4,091.8          |
| 16           | Цагааннуур  | 4,555.9          |
| 17           | Шаамар      | 2,696.3          |
| <b>НИЙТ</b>  |             | <b>86,901.8</b>  |

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын төсөв баталсан тогтоолууд

**1.2.6** Тусгайлан зохицуулсан хууль, журам байхгүй атал Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан *“Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-д: “Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх” /81518/* гэж тусгасныг үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардалд аймаг 788.0 сая төгрөг, Ерөө сум 446.7 сая төгрөг, Мандал сум 70.0 сая төгрөг, Сайхан сум 20.0 сая төгрөг, Хүдэр сум 19.9 сая төгрөгийг тус тус холбогдох тооцоо судалгаа, нотлох баримтгүйгээр бөөн дүнгээр баталсан нь хөрөнгө худалдан авах, урсгал үйл ажиллагааг санхүүжүүлэх, тэтгэмж, шагнал олгох гэх мэтчилэн төсвийн цоорхойг нөхөхөд үрэлгэн байдлаар зарцуулах эрсдэлийг үүсгэсэн байна.

**1.2.7** 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй дараах төсөл, арга хэмжээг тусгаж, баталсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.2.1 дэх заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- *Баянгол сум “Үер усны аюулаас сэргийлэх аврах завь, мотор, багаж худалдан авах” төсөл, арга хэмжээнд 35.0 сая төгрөг,*
- *Орхонтуул сум “Явуулын иргэний танхимын үйлчилгээ үзүүлэх авто машин худалдан авах” төсөл, арга хэмжээнд 70.0 сая төгрөг.*

**1.2.8** Зураг, төсөв нь урьдчилан хийгдээгүй **929.2** сая төгрөгийн **17** төсөл арга хэмжээг аймгийн ОНХО-ийн эх үүсвэрээр, **294.9** сая төгрөгийн **3** төсөл арга хэмжээг аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3.3 дахь заалтуудыг зөрчсөн байна.

**1.2.9** ОНХС-ийн чиг үүрэгт үл хамаарах дараах төсөл, арга хэмжээг ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр баталсан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2.1-4.2.8 болон 4.4.1-4.4.9 дахь заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- *Аймаг “Аймгийн Цагдаагийн газарт тоноглогдсон автомашин худалдан авах” төсөл, арга хэмжээнд аймаг 205.0 сая төгрөг,*
- *Ерөө сум “Багийн байр барих” төсөл, арга хэмжээнд 113.1 сая төгрөг,*
- *Мандал сум “Хаягжуулалт” төсөл, арга хэмжээнд 154.4 сая төгрөг,*
- *Цагааннуур сум “Урлагийн хувцас худалдан авах” төсөл, арга хэмжээнд 45.0 сая төгрөг,*
- *Шаамар сум “Төрийн албан хаагчдын байр худалдан авах” төсөл, арга хэмжээнд 191.0 сая төгрөг.*

**1.2.10** Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй 328.1 сая төгрөгийн дараах төсөл, арга хэмжээг аймгийн ОНХО-ын жагсаалтад тусгаж төсөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- *Нийтийн эзэмшлийн байруудын засвар /Сүхбаатар 7-р баг/ -ын төсөл, арга хэмжээнд 199.7 сая төгрөг,*

- 12 айлын байрны дээвэр /Сант сум/-ын төсөл, арга хэмжээнд 81.6 сая төгрөг,
- 16 айлын орон сууцны засвар /Сүхбаатар сум Ганзам 7-р баг/ -ын төсөл, арга хэмжээнд 46.8 сая төгрөг,

**1.2.11** Аймгийн ОНХО-аар хөрөнгө оруулалтын шинж чанартай бус хэт жижиглэсэн буюу байгууллагын урсгал зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой нийт 196.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг буруулж, зорилго зорилтыг алдагдуулж байна.

**1.2.12** Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд тусгагдаагүй атал төлөөлөгчид санал гаргаж, хэлэлцэн, баталсан гэх үндэслэлээр аймаг ИТХ-д суудалтай 2 намд нэг суудлыг 5.0 сая төгрөгөөр тооцон нийт **185.0** сая төгрөгийг, Сүхбаатар сум нэг суудлыг 2.0 сая төгрөгөөр тооцон нийт **62.0** сая төгрөгийг төлөвлөж, баталсан байна. Энэ нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх “Нам дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 10.1.5: Энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс ... санхүүжилт шууд болон шууд бусаар авах; 34.6.3: Төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага” гэсэн заалтыг зөрчсөн байна.

### **1.3. Төсвийн жилийн дундуур орон нутгийн төсөвт тодотгол хийгдсэн эсэх?**

*Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад аймаг болон зарим сумдууд хөрөнгө оруулалт, байгууллагын урсгал зардлыг нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийсэн байна*

**1.3.1** УИХ-ын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулан Сэлэнгэ аймгаас улсын төсөвт шилжүүлэх орлогыг 944.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,307.9 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 1,239.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 27,768.4 сая төгрөгөөр баталсныг үндэслэн аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор дараах өөрчлөлтийг хийж, аймгийн 2024 оны төсвийн нийт орлого, зарлагыг тус бүр **7,984.9** сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгон **74,545.8** сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

#### **Орлого талд:**

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 8,548.9 сая төгрөг,
- Улсын тэмдэгтийн хураамжийг 920.2 сая төгрөг,
- Ус ашигласны төлбөрийг 552.5 сая төгрөг,
- Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 200.0 сая төгрөг,
- Сумын төсвөөс аймагт төвлөрүүлэх орлогыг 327.9 сая төгрөг,
- Хөрөнгө борлуулсны орлогыг 130.0 сая төгрөг,
- Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 1,239.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр,
- Нэр заагдаж ангилагдаагүй бусад орлогыг 2,400.0 сая төгрөгөөр,
- Аймгийн төсвийн урьд оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс санхүүжих дүнг 1,512.6 сая төгрөгөөр,
- Аймгийн ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих дүнг 21.4 сая төгрөгөөр бууруулахаар тооцож, нийт дүнгээр орлогыг **7,984.9** сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

### Зарлага талд:

- Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 944.7 сая төгрөгөөр,
- Аймгийн хөрөнгө оруулалтын зардлыг 2,745.4 сая төгрөгөөр,
- Аймгийн ОНХС-ийн зардлыг 474.4 сая төгрөгөөр,
- Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 743.6 сая төгрөгөөр,
- Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг 401.4 сая төгрөгөөр,
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 440.0 сая төгрөгөөр,
- Улсын төсвийн байгууллагуудад олгох орон нутгийн нэмэгдлийг 670.4 сая төгрөгөөр,
- Улсын төсвийн байгууллагуудад олгох тогтмол зардлыг 1,118.4 сая төгрөгөөр,
- Аймгийн төсвийн урсгал зардлыг 142.4 сая төгрөгөөр,
- Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 304.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нийт дүнгээр зарлагыг **7,984.9** сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцсон байна.

Хүснэгт №3. Аймгийн төсвийн эцэслэн тодотгож баталсан төлөвлөгөө

/сая төгрөг/

| №  | Үзүүлэлт  | УИХ-аар баталсан дүн | 2024 он         |                 |
|----|---|----------------------|-----------------|-----------------|
|    |   |                      | Анх баталсан    | Тодотгол        |
| А  | Б   | 1                    | 2               | 3               |
| 1  | <b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>  | <b>52,430.7</b>      | <b>66,560.8</b> | <b>74,545.8</b> |
| 2  | <b>УРСГАЛ ОРЛОГО</b>  | <b>21,509.0</b>      | <b>29,938.9</b> | <b>37,890.5</b> |
| 3  | Татварын орлого   | 20,600.0             | 24,201.1        | 34,422.7        |
| 4  | Татварын бус орлого   | 909.0                | 5,737.8         | 3,467.8         |
| 5  | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас төвлөрүүлэх орлого  | 26,529.0             | 26,529.0        | 27,768.4        |
| 6  | БУСАД ЭХ ҮҮСВЭР /Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого/   | 4,392.7              | 7,118.4         | 7,446.4         |
| 7  | Байгууллагын өөрийн орлого  | -                    | 47.0            | 47.0            |
| 8  | <b>ӨМНӨХ ОНЫ ҮНДСЭН ТЭНЦЛИЙН АШИГ</b> /өмнөх оны давсан орлогоос, хэмнэгдсэн зардлаас, мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс/ | -                    | 2,927.5         | 1,393.5         |
| 9  | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>  | <b>52,430.7</b>      | <b>66,560.8</b> | <b>74,545.8</b> |
| 10 | УРСГАЛ ЗАРДАЛ   | 24,336.5             | 30,802.0        | 33,879.0        |
| 11 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ   | 24,336.5             | 30,802.0        | 33,879.0        |
| 12 | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>   | <b>26,730.9</b>      | <b>34,395.5</b> | <b>38,358.9</b> |
| 13 | Аймгийн төсвөөс улсын төсөвт шилжүүлэх орлого   | 1,363.3              | 1,363.3         | 2,307.9         |
| 14 | <b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>  | -                    | -               | -               |

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

**1.3.2** Аймгийн төсөвт тодотгол хийгдсэнтэй холбогдуулан сумдын ИТХ-аас тус тусын сумын төсөвт тодотгол хийж, анх батлагдсан төсвийг нийт **3,493.2** сая төгрөгөөр нэмэгдүүлэн **90,395.0** сая төгрөгөөр эцэслэн баталсан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 3-д харуулав/

**1.3.3** Дээд шатны төсөвт тодотгол хийгдсэн гэх үндэслэлээр улсын төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг дагалдуулалгүйгээр зайлшгүй шаардлага үүсээгүй байхад аймаг болон сумдууд хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг 3,878.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийсэн байна. Үүнд:

- Аймгийн хөрөнгө оруулалтын зардлыг 2,745.4 сая төгрөгөөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 440.0 сая төгрөгөөр,

- Мандал сум ОНХО-ын зардлыг 515.0 сая төгрөгөөр,
- Сүхбаатар сум ОНХО-ын зардлыг 54.9 сая төгрөгөөр,
- Сайхан сум ОНХО-ын зардлыг 18.0 сая төгрөгөөр,
- Баруунбүрэн сум ИТХ-ын урсгал зардлыг 10.0 сая төгрөгөөр, ЗДТГ-ын урсгал зардлыг 90.0 сая төгрөгөөр,
- Орхонтуул сум ЗДТГ-ын урсгал зардлыг 5.0 сая төгрөг өөр гэх мэт.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2 дахь “Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”, 34.2.2: “Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн **төсөв алдагдалтай болох** нөхцөл байдал бий болсон” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**1.3.4** Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас сумдын 2024 оны төсвийн суурь орлогыг анх 2023 оны 12 дугаар сард хянахдаа аймгийн төсвийн орлогод тооцогдох зохицуулалттай үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр болон малын тоо толгойн албан татварын орлогыг суурь орлогод тооцсоныг дараах сумдууд төсвийн тодотголоор залруулан тооцсон байна. Үүнд:

- Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн 553.8 сая төгрөгийг Ерөө, Мандал, Хүдэр, Жавхлант, Орхонтуул, Сайхан, Түшиг зэрэг нийт 7 сумын суурь орлогод оруулан тооцсоныг тодотголоор залруулсан,
- 17 сумын малын тоо толгойн албан татварын 2,837.4 сая төгрөгийг сумын суурь орлогод оруулан тооцсоныг Зүүнбүрэн, Сант сумаас бусад сумдын 2,608.4 сая төгрөгийн орлого гэх мэт.

**1.3.5** Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1, 42.2.2 дахь заалтын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар 4 удаа, сумдын Засаг даргын захирамжаар тус бүр 1-4 удаа төсвийн зохицуулалт хийсэн байна.

## **БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛСЭН ҮҮ?**

**2.1 Татварын ба татварын бус орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн ашиглаж, төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх?**

*Тодорхой шалтгаануудын улмаас татварын ба татварын бус орлогын төлөвлөгөөг аймаг 3,947.0 сая төгрөгөөр, 6 сум нийт 3,336.0 сая төгрөгөөр тус тус тасалсан байна*

**2.1.1** Аймаг, сумдын орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 90,288.3 сая төгрөгөөр эцэслэн төлөвлөснөөс гүйцэтгэлээр 90,489.3 сая төгрөг төвлөрүүлж, **100.2** хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Хүснэгт №4. Аймаг, сумдын төсвийн орлогын гүйцэтгэл

*/сая төгрөг/*

| Орлогын нэр төрөл                    | 2023 оны гүйцэтгэл | 2024 он         |                 |                 |                 |                 |                 |                |              |
|--------------------------------------|--------------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|----------------|--------------|
|                                      |                    | Аймаг           |                 | Сумд            |                 | Нийт орлого     |                 |                |              |
|                                      |                    | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл       | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл       | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл       | Зөрүү          | Хувь         |
| <b>Татварын орлого</b>               | <b>64,825.0</b>    | <b>34,422.7</b> | <b>32,130.1</b> | <b>48,909.6</b> | <b>51,981.4</b> | <b>83,332.3</b> | <b>84,111.5</b> | <b>779.2</b>   | <b>100.9</b> |
| Хувь хүний орлогын албан татвар      | 30,398.2           |                 | 249.9           | 39,155.5        | 43,506.3        | 39,155.5        | 43,756.2        | 4,600.7        | 111.7        |
| ХХОАТ-ын буцаалт                     | (1,671.8)          |                 |                 | (2,159.6)       | (2,193.8)       | (2,159.6)       | (2,193.8)       | (34.2)         | 101.6        |
| Аж ахуй нэгжийн орлогын албан татвар | 21,050.0           | 29,700.0        | 26,181.0        |                 |                 | 29,700.0        | 26,181.0        | (3,519.0)      | 88.2         |
| Хөрөнгийн албан татвар               | 4,742.6            | 1,000.0         | 1,106.6         | 4,169.5         | 3,982.0         | 5,169.5         | 5,088.6         | (80.9)         | 98.4         |
| Бусад татвар, төлбөр, хураамж        | 10,306.0           | 3,722.7         | 4,592.6         | 7,744.2         | 6,686.9         | 11,466.9        | 11,279.5        | (187.4)        | 98.4         |
| <b>Татварын бус орлого</b>           | <b>4,834.6</b>     | <b>3,467.8</b>  | <b>1,823.0</b>  | <b>3,488.2</b>  | <b>4,554.8</b>  | <b>6,956.0</b>  | <b>6,377.8</b>  | <b>(578.2)</b> | <b>91.7</b>  |
| Хүү, торгуулийн орлого               | 2,567.6            | 1,750.0         | 844.7           | 2,158.6         | 2,830.9         | 3,908.6         | 3,675.6         | (233.0)        | 94.0         |
| Нэр зааж ангилагдаагүй орлого        | 2,065.1            | 1,587.8         | 749.8           | 1,320.3         | 1,713.4         | 2,908.1         | 2,463.2         | (444.9)        | 84.7         |
| Түрээсийн орлого                     |                    |                 |                 | 9.3             | 10.5            | 9.3             | 10.5            |                | 1.2          |
| Хөрөнгийн орлого                     | 171.9              | 130.0           | 228.5           |                 |                 | 130.0           | 228.5           |                | 98.5         |
| Хандив, тусламжийн орлого            | 30.0               |                 |                 |                 |                 | -               | -               | -              | -            |
| <b>НИЙТ ТӨСВИЙН ОРЛОГО</b>           | <b>69,659.6</b>    | <b>37,890.5</b> | <b>33,953.1</b> | <b>52,397.8</b> | <b>56,536.2</b> | <b>90,288.3</b> | <b>90,489.3</b> | <b>201.0</b>   | <b>100.2</b> |

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тодотгосон төсөв баталсан тогтоолууд, аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

**2.1.2** Сангийн яамнаас 12 сарын аж ахуйн нэгжийн орлогыг тухайн сард нь бус 2025 оны 01 дүгээр сард аймгийн төсөвт шилжүүлснээс 2024 оны аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 3,937.4 сая төгрөгөөр буюу 10.4 хувиар тасарсан байна.

**2.1.3** Сумдын дүнгээр татварын болон татварын бус орлогыг 7.9 хувиар буюу 4,138.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн бөгөөд аймгийн төсвөөс 11,772.4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан байна.

Хүснэгт №5. Сумдын тодотгосон төсвийн орлогын гүйцэтгэл, санхүүгийн дэмжлэг

/сая төгрөг/

| Д/д | Сумдын нэр  | Сумдын төсвийн тодотгосон орлого |           |           | Биелэлтийн хувь | Санхүүгийн дэмжлэг |           | Хувь  |
|-----|-------------|----------------------------------|-----------|-----------|-----------------|--------------------|-----------|-------|
|     |             | Төлөвлөгөө                       | Гүйцэтгэл | Зөрүү     |                 | Төлөвлөгөө         | Гүйцэтгэл |       |
| 1   | Алтанбулаг  | 1,039.5                          | 1,137.4   | 97.9      | 109.4           | 843.3              | 843.3     | 100.0 |
| 2   | Баруунбүрэн | 825.2                            | 1,295.5   | 470.3     | 157.0           | 1,225.6            | 1,225.6   | 100.0 |
| 3   | Баянгол     | 1,946.6                          | 2,746.9   | 800.3     | 141.1           | 301.5              | 301.5     | 100.0 |
| 4   | Ерөө        | 8,417.6                          | 6,028.1   | (2,389.5) | 71.6            | -                  | -         | -     |
| 5   | Жавхлант    | 509.6                            | 589.0     | 79.4      | 115.6           | 1,140.1            | 1,140.1   | 100.0 |
| 6   | Зүүнбүрэн   | 1,005.0                          | 957.7     | (47.3)    | 95.3            | 890.5              | 890.5     | 100.0 |
| 7   | Мандал      | 10,468.5                         | 13,595.9  | 3,127.4   | 129.9           | -                  | -         | -     |
| 8   | Орхон       | 716.1                            | 885.0     | 168.9     | 123.6           | 785.5              | 785.5     | 100.0 |
| 9   | Орхонтуул   | 893.5                            | 904.3     | 10.8      | 101.2           | 1,527.9            | 1,527.9   | 100.0 |
| 10  | Сайхан      | 5,232.1                          | 5,576.3   | 344.2     | 106.6           | -                  | -         | -     |
| 11  | Сант        | 729.3                            | 619.3     | (110.0)   | 84.9            | 852.6              | 852.6     | 100.0 |
| 12  | Сүхбаатар   | 12,956.2                         | 14,705.1  | 1,748.9   | 113.5           | -                  | -         | -     |
| 13  | Түшиг       | 826.8                            | 749.2     | (77.6)    | 90.6            | 1,184.2            | 1,184.2   | 100.0 |
| 14  | Хушаат      | 608.4                            | 810.9     | 202.5     | 133.3           | 1,091.3            | 1,091.3   | 100.0 |
| 15  | Хүдэр       | 3,495.4                          | 2,948.0   | (547.4)   | 84.3            | -                  | -         | -     |
| 16  | Цагааннуур  | 1,781.2                          | 1,617.0   | (164.2)   | 90.8            | 546.1              | 546.1     | 100.0 |
| 17  | Шаамар      | 946.8                            | 1,370.6   | 423.8     | 144.8           | 1,383.8            | 1,383.8   | 100.0 |

|  |            |                 |                 |                |              |                 |                 |              |
|--|------------|-----------------|-----------------|----------------|--------------|-----------------|-----------------|--------------|
|  | <b>Дүн</b> | <b>52,397.8</b> | <b>56,536.2</b> | <b>4,138.4</b> | <b>107.9</b> | <b>11,772.4</b> | <b>11,772.4</b> | <b>100.0</b> |
|--|------------|-----------------|-----------------|----------------|--------------|-----------------|-----------------|--------------|

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоол, Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

**2.1.4** Сумдын татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг дараах сумд тодорхой шалтгаануудын улмаас тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- *Болдтөмөр Ерөө гол” ХХК ХХОАТ-ын орлогыг 10 дугаар сараас эхлэн шилжүүлээгүйгээс голлон шалтгаалж Ерөө сум 2,389.5 сая төгрөгөөр,*
- *ЗГ-аас авто замын карьерын төлбөрийг чөлөөлснөөс түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого тасарснаас голлон шалтгаалж Түшиг сум 77.6 сая төгрөгөөр,*
- *Аймгийн ИТХ-аас мод бэлтгэх хуваарьт өөрчлөлт оруулан, бэлтгэх модны хэмжээг бууруулснаас Цагааннуур сумын ойн дагалт баялаг ашигласны төлбөрийн орлого тасарснаас 164.2 сая төгрөгөөр,*
- *Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас сумдын суурь орлогын төлөвлөгөөг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн тооцсоноос дараах 3 сумын татварын орлогын төлөвлөгөө тасарсан байна. Үүнд:*
  - *Самрын нөөц тогтоогдоогүй байхад ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 3 жилийн дунджаар төлөвлөснөөс шалтгаалж, орлогын төлөвлөгөөг Хүдэр сум 547.4 сая төгрөгөөр,*
  - *Малын тоо толгойн албан татвар 120.0 сая төгрөгийг сумын суурь орлогод тооцон баталснаас Зүүнбүрэн сум суурь зардлаа нөхөхийн тулд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг хэт өндрөөр төлөвлөж, 47.3 сая төгрөгөөр,*
  - *Малын тоо толгойн албан татвар 98.7 сая төгрөгийг сумын суурь орлогод тооцож баталсан, ҮХХАТ-ыг тооцооллын алдаанаас шалтгаалан хэт өндрөөр баталснаас Сант сум суурь зардлаа нөхөхийн тулд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг хэт өндрөөр төлөвлөж, 110.0 сая төгрөгөөр гэх мэт.*

**2.1.5** 2024 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр<sup>2</sup> зүйлд заасны дагуу аймгийн татварын орлогыг төлөвлөхдөө өмнөх оны татварын өр төлбөрийн 70.0 хувийг тайлант онд барагдуулахаар тооцоогүй байна.

**2.1.6** 2023 оны жилийн эцсийн байдлаар 16,848.1 сая төгрөгийн татварын өр төлбөртэй тайлагдсанаас дунджаар 50.0 хувийг нь барагдуулахаар тооцоход төсвийн орлого **8,424.0 сая** төгрөгөөр нэмэгдэх боломжийг төлөвлөөгүй байна. Гэтэл гүйцэтгэлээр 2023 оны жилийн эцсийн өр төлбөрөөс 69.9 хувь буюу 11,776.9 сая төгрөгийг тайлант онд барагдуулсан байна.

**2.2. Төсөвт байгууллагуудын төлөвлөсөн өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж, нөөц боломжийг ашигласан эсэх?**

<sup>2</sup> хавсралтад “өмнөх оны татварын өр барагдуулалтыг 70 хувиар, тайлант хугацааны татварын тайлангийн ногдол өр барагдуулалтыг 80 хувиар тооцно”

*Төсөвт байгууллагын өөрийн орлогыг аймаг, сумдын төсөвт байгууллагууд нийт 23.9 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна*

**2.2.1** Тайлант онд аймаг, сумдын байгууллагуудын өөрийн орлогыг 500.0 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 511.1 сая төгрөг төвлөрч, төлөвлөгөөг 2.2 хувиар букуу 11.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

**2.2.2** Байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6. Төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

*/сая төгрөг/*

| д/д             | Сумын нэр   | Байгууллагын нэр                        | 2024 оны     |              |             |              |
|-----------------|-------------|---|--------------|--------------|-------------|--------------|
|                 |             |   | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл    | Зөрүү       | Хувь         |
| 1               | Сүхбаатар   | Аймгийн ЗДТГ                            | 45.0         | 55.3         | 10.3        | 122.9        |
| 2               | Сүхбаатар   | Аймгийн Худалдан авах ажиллагааны газар | 2.0          | 12.7         | 10.7        | 6 дахин      |
| 3               | Алтанбулаг  | ЗДТГ                                    | 0.5          | 1.1          | 0.6         | 2.2 дахин    |
| 4               | Баруунбүрэн | ЗДТГ                                    | 29.3         | 31.8         | 2.5         | 108.5        |
|                 |             | Орхон бүсийн ойн анги                   | 20.0         | 21.3         | 1.3         | 106.5        |
| 5               | Баянгол     | ЗДТГ                                    | 5.0          | 6.5          | 1.5         | 130.0        |
| 6               | Ерөө        | ЗДТГ                                    | 0.5          | -            | (0.5)       | -            |
|                 |             | Ойн анги                                | 123.1        | 122.6        | (0.5)       | 99.6         |
| 7               | Жавхлант    | ЗДТГ                                    | 0.9          | 1.0          | 0.1         | 110.0        |
| 8               | Зүүнбүрэн   | ЗДТГ                                    | 4.1          | 4.1          | -           | 100.0        |
| 9               | Мандал      | Түнхэл Захирагчийн алба                 | 5.2          | 5.5          | 0.3         | 105.8        |
|                 |             | Ойн анги                                | 90.0         | 104.5        | 14.5        | 116.1        |
| 10              | Орхон       | ЗДТГ                                    | 0.6          | 2.0          | 1.4         | 3 дахин      |
| 11              | Орхонтуул   | ЗДТГ                                    | 0.5          | 0.5          | -           | 100.0        |
| 12              | Сант        | ЗДТГ                                    | 5.0          | 1.9          | (3.1)       | 38.0         |
| 13              | Сүхбаатар   | ЗДТГ                                    | 1.0          | 2.2          | 1.2         | 2.2 дахин    |
|                 |             | Ойн анги                                | 45.0         | 19.0         | (26.0)      | 42.2         |
| 14              | Түшиг       | ЗДТГ                                    | 0.5          | 2.5          | 2.0         | 5 дахин      |
| 15              | Цагааннуур  | ЗДТГ                                    | 0.5          | 7.4          | 6.9         | 15 дахин     |
|                 |             | Ойн анги                                | 89.1         | 71.2         | (17.9)      | 79.9         |
| 16              | Шаамар      | ЗДТГ                                    | 9.7          | 10.9         | 1.2         | 112.4        |
|                 |             | Дулаанхаан тосгоны захирагчийн алба     | 22.5         | 27.1         | 4.6         | 120.4        |
| <b>Нийт дүн</b> |             |   | <b>500.0</b> | <b>511.1</b> | <b>11.1</b> | <b>102.2</b> |

*Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан*

**2.2.3** Өөрийн орлогын төлөвлөгөөг 5 байгууллага нийт 48.0 сая төгрөгөөр тасалж, 17 байгууллага 59.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн бөгөөд батлагдсан төлөвлөгөөг тасалснаас 48.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх нөөц боломжийг алдсан байна.

**2.2.4** Аймгийн ИТХ-аас мод бэлтгэх хуваарьт өөрчлөлт оруулан, бэлтгэх модны хэмжээг бууруулснаас Сүхбаатар, Цагааннуур сумын Ойн ангиудын өөрийн орлого 43.9 сая төгрөгөөр тасарсан байна.

**2.2.5** Төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны өөрийн орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дунджаар тооцон төлөвлөхөөр зохицуулагдсан атал дараах байгууллагууд нийт 23.9 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна. Үүнд:

- Алтанбулаг сумын ЗДТГ 0.6 сая төгрөгөөр,

- Сүхбаатар сумын ЗДТГ нь 2.2 сая төгрөгөөр,
- Орхон сумын ЗДТГ нь 1.5 сая төгрөгөөр,
- Түшиг сумдын ЗДТГ нь 2.0 сая төгрөгөөр,
- Цагааннуур сумын ЗДТГ 6.9 сая төгрөгөөр,
- Аймгийн Худалдан авах ажиллагааны газар 10.7 сая төгрөгөөр гэх мэт.

### БҮЛЭГ 3. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ, ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛСАН УУ?

#### 3.1 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан бодитой, үнэн зөв эсэх?

Аймаг, сумдын дүнгээр төсвийн зарлагын төлөвлөгөө 81.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна

**3.1.1** Сэлэнгэ аймгийн 2024 оны төсвийн нийт зарлагыг 135,528.4 сая төгрөгөөр /сумдын ИТХ-аар баталсан дүн орсон/ баталснаас 109,717.0 сая төгрөгийн буюу 81.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 18,104.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Нийт зарлагын гүйцэтгэл

/сая төгрөг/

| Код        | Үзүүлэлт   | Өмнөх оны гүйцэтгэл | 2024 он           |                  |                   |              |
|------------|--|---------------------|-------------------|------------------|-------------------|--------------|
|            |  |                     | Тодотгон баталсан | Гүйцэтгэл        | Зөрүү             | Хувь         |
| А          | Б  | 1.0                 | 3.0               | 4.0              | 5=4-3             |              |
| <b>2</b>   | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                 | <b>91,612.1</b>     | <b>135,528.4</b>  | <b>109,717.0</b> | <b>(25,811.4)</b> | <b>81.0</b>  |
| <b>21</b>  | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                     | <b>56,476.9</b>     | <b>80,296.3</b>   | <b>71,797.2</b>  | <b>(8,499.1)</b>  | <b>89.4</b>  |
| <b>210</b> | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                   | <b>50,513.2</b>     | <b>72,981.9</b>   | <b>66,045.7</b>  | <b>(6,936.2)</b>  | <b>90.5</b>  |
| 2101       | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил                       | 15,761.9            | 27,357.8          | 24,739.2         | (2,618.6)         | 90.4         |
| 2102       | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 1,969.1             | 3,490.1           | 3,056.1          | (434.0)           | 87.6         |
| 2103       | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 15,634.9            | 20,147.4          | 18,845.7         | (1,301.7)         | 93.5         |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал                         | 1,349.5             | 1,603.6           | 1,483.9          | (119.7)           | 92.5         |
| 2105       | Нормативт зардал   | 12.2                | 28.7              | 23.1             | (5.6)             | 80.5         |
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 2,965.7             | 2,971.4           | 2,828.5          | (142.9)           | 95.2         |
| 2107       | Томилолт, зочны зардал                                   | 354.9               | 524.8             | 451.0            | (73.8)            | 85.9         |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,616.5             | 5,515.7           | 4,344.3          | (1,171.4)         | 78.8         |
| 2109       | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 7,848.5             | 11,342.4          | 10,273.9         | (1,068.5)         | 90.6         |
| <b>212</b> | <b>ТАТААС</b>  | <b>131.4</b>        | <b>125.9</b>      | <b>125.9</b>     | <b>-</b>          | <b>100.0</b> |
| <b>213</b> | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  | <b>5,832.3</b>      | <b>7,188.5</b>    | <b>5,625.6</b>   | <b>(1,562.9)</b>  | <b>78.3</b>  |
| <b>22</b>  | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                  | <b>33,373.0</b>     | <b>52,419.2</b>   | <b>37,556.4</b>  | <b>(14,862.8)</b> | <b>71.6</b>  |
| <b>23</b>  | <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>        | <b>1,762.2</b>      | <b>2,812.9</b>    | <b>363.4</b>     | <b>(2,449.5)</b>  | <b>12.9</b>  |


Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

**3.1.2** Орон нутгийн төсвийн нийт зарлагыг эдийн засгийн ангиллаар нь задалж үзвэл бараа, ажил үйлчилгээний зардал 90.5 хувийн, урсгал шилжүүлэг 78.3 хувийн,

хөрөнгийн зардал 71.6 хувийн, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 12.9 хувийн гүйцэтгэлтэй буюу нийт 25,811.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

**3.1.3** Нийт төсвийн зарлагын 34.2 хувийг хөрөнгийн зардал, 25.3 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 17.2 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 5.1 хувийг урсгал шилжүүлгийн зардал, 0.3 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл, 17.9 хувийг бусад зардал эзэлж байна.

**График №1 Орон нутгийн төсвийн нийт зарлагын бүтэц**



**3.1.4** Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 109,717.0 сая төгрөг буюу 81.0 хувьтай байгаа нь хөрөнгийн зардлыг 14,862.8 сая төгрөгөөр, урсгал зардлыг 8,499.1 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 1,562.9 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 2,449.5 сая төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 3,052.6 сая төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,301.7 сая төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардал 119.7 сая төгрөгөөр,
- Нормативт зардал 5.6 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 142.9 сая төгрөгөөр,
- Албан томилолтын зардал 73.8 сая төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,171.4 сая төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардал 1,068.5 сая төгрөгөөр,
- Урсгал шилжүүлэг 1,562.9 сая төгрөгөөр гэх мэт.

**3.1.5** Аймаг, сумдын төсвийн байгууллагууд нийт 46 орон тоо дутуу ажилласнаас цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал 3,052.6 сая төгрөгөөр, аймаг, сумын ОНХС, ОНХО-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэнээс хөрөнгийн зардал 14,862.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь төсвийн зардлын хэмнэлтэд голлон нөлөөлсөн байна.

**3.1.6** Аймгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн орлогыг 428.5 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлийг зөрчсөн байна.

## 3.2 Батлагдсан төсвийг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд зориулалтын дагуу зарцуулсан эсэх?

*Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд нь батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиг, арвилан хэмнэлтгүй зарцуулсан зөрчил илэрсэн байна*

**3.2.1** Аймгийн ТЕЗ, түүний харьяа байгууллагууд нь батлагдсан төсвийг зардлын хөтөлбөр болон бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан нийт **214.1 сая** төгрөгийн зөрчил илэрсэн байна. /Аймаг, сумдын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар зөрчлөөр тооцогдож, албан шаардлага хүргүүлсэн/Үүнд:

- Аймгийн ЗДТГ 18.7 сая төгрөг,
- Аймгийн ИТХ 18.0 сая төгрөг,
- 14 сумын ТТЗ нь 177.4 сая төгрөг гэх мэт.

**3.2.2** Аймаг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан нийт **304.5 сая** төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс жил бүр тогтмол гардаг, урьдчилан төлөвлөх боломжтой, аймгийн ЗДТГ-ын болон бусад байгууллагын урсгал төсөвт тусган хэрэгжүүлэх боломжтой цэрэг татлага, сургалт, зөвлөгөөн зочин төлөөлөгч хүлээн авах, алдартнуудад хүндэтгэл үзүүлэх зэрэг үйл ажиллагаанд нийт 77.3 сая төгрөг,
- Сумдууд тохижилт, үйлчилгээний зардал, ойн тэмдэглэх болон баярын үйл ажиллагаа, сургалт зөвлөгөөн, цэрэг татлага зэрэг үйл ажиллагаанд нийт 227.2 сая төгрөг гэх мэт.

**3.2.3** Дараах байгууллагууд батлагдсан төсвийг үр ашиг, арвилан хэмнэлтгүй зарцуулсан 64.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.Үүнд:

- Аймгийн ИТХ нь хурлын төлөөлөгчдийн хоолны зардлыг илүү зарцуулсан, үндсэн орон тоотой давхардуулан гэрээт ажилтан ажиллуулсан зэрэг нийт 19.0 сая төгрөгийн,
- Сүхбаатар сумын ИТХ нь төлөөлөгчдийн хоолны зардлыг илүү зарцуулсан, үр дүн, үр нөлөөгүй сургалт хэлэлцүүлэг зохион байгуулсан гэх мэт нийт 45.7 сая төгрөгийн.

**3.2.4** Зарцуулалтыг нь хууль, эрхийн актаар зохицуулаагүй аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын төсвөөс улсын болон орон нутгийн төсөвт байгууллагуудад техник, тоног төхөөрөмж, хөрөнгө худалдан авах болон урсгал зардалд нийт 459.4 сая төгрөгийг зарцуулсан байна.Үүнд:

- Аймгийн ТЕЗ нь 413.6 сая төгрөг,
- Ерөө, Мандал сумд нь нийт 45.8 сая төгрөг.

**3.2.5** Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд орон нутгийн төсвийн байгууллагуудаас судалгаа авч, горим сорил хэрэгжүүлэхэд дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

**Орон тоо, цалингийн сантай холбоотой:**

ТЕЗ-ийн харьяа дараах байгууллагууд нь бүтэц, орон тоонд батлагдаагүй албан хаагчдыг томилж, ажиллуулан нийт **143.6** сая төгрөгийн цалин хөлс олгосныг санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлөөр тооцож, албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

- Баруунбүрэн сумын ЗДТГ нь нотариатын асуудал хариуцсан 1 ажилтан,
- Сүхбаатар сумын ЗДТГ нь худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт болон байгууллагын дотоод ажил, батлан хамгаалах, гамшгийн асуудал хариуцсан мэргэжилтэн зэрэг 2 ажилтан,
- Орхонтуул сумын ЗДТГ нь гатлагат онгоцны операторчин 1 ажилтан,
- Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн алба нь тохижилт үйлчилгээ хариуцсан ажилтан, галч-жижүүр, ковш машины жолооч зэрэг 3 ажилтан,
- Аймгийн худалдан авах ажиллагааны газар нь албаны эзэмшилд бүртгэлтэй автомашингүй атал гэрээт жолооч,
- Ерөө сумын Бугант тосгоны Захирагчийн алба нь биеийн тамирын арга зүйч гэх мэт.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

### **Худалдан авах ажиллагаатай холбоотой**

Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй **321.5** сая төгрөгийн дараах зөрчлүүдийг санхүүгийн тайлангийн аудитын зөрчлөөр тооцож, албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

- Баруунбүрэн сум нь харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулахаас зайлсхийж гэрээ шууд байгуулах аргын босго үнэд багтаах зорилгоор 140.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий худаг гаргах төсөл, арга хэмжээг 7 төсөл, арга хэмжээ болгон төлөвлөж, урьдчилгаа санхүүжилт олгон хэрэгжүүлсэн,
- Баруунбүрэн сумын ЗДТГ нь шууд худалдан авах босго үнээс давсан 49.5 сая төгрөгийн шатахууны худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн,
- Баянгол сум нь хөтөлбөр, арга хэмжээ нь тусдаа батлагдсан хэдий ч нийт дүнгээрээ худалдан авах босго үнээс давсан 42.0 сая төгрөгийн шатахууны худалдан авалтын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулаагүй,
- Орхонтуул сум нь ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар тус бүр 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн хүүхдийн тоглоомыг нэмэгдүүлэх, шинэчлэх”, “Бөхийн дэвжээ худалдан авах” төсөл, арга хэмжээг аж ахуйн нэгж бус “Ирээдүйд хөтөлсөн өргөө”, “Орхонтуулын хүчтэн” НҮТББ-уудтай гэрээ шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн,
- Рашаант тосгоны Захирагчийн алба нь шууд худалдан авах босго үнээс давсан 48.0 сая төгрөгийн нүүрсний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулаагүй,
- Сүхбаатар сумын ИТХ нь харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулахаас зайлсхийж, шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарт багтаах зорилгоор 22.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “2020-2024 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн тайлан”-г эх бэлтгэл, хэвлэлт гэж 2 хуваан төлөвлөж, хэрэгжүүлсэн гэх мэт.

Эдгээр нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, 35 дугаар зүйлийн 35.2, 54 дүгээр зүйлийн 54.8, Засгийн газрын 2024 онд батлагдсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1-д заасныг тус тус зөрчсөн байна.

### **3.3 ОНХС, ОНХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн эсэх?**

*Аймаг, сумын ОНХО болон ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс 177 төсөл, арга хэмжээ буюу 29.3 хувь нь дутуу болон огт хэрэгжээгүй байна.*

**3.3.1** Тайлант онд аймгийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгөөр 9,213.7 сая төгрөгийн 112 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталснаас 6,387.2 сая төгрөгийн 71 төсөл арга хэмжээ бүрэн, 817.6 сая төгрөгийн 8 арга хэмжээ дутуу хэрэгжиж, 2,008.9 сая төгрөгийн 33 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

**3.3.2** Аудитаар аймгийн ОНХО-ын санхүүжилттэй холбоотой нийт **101.6** сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээний 74.6 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг банкны болон даатгалын байгууллагаар баталгаажуулалгүйгээр гэрээ байгуулсан,
- Тайлант онд бүрэн хэрэгжсэн 2 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид олгох санхүүжилтээс суутган тооцож авах ёстой чанарын баталгааны барьцааг тооцооллын алдааны улмаас 14.2 сая төгрөгөөр дутуу суутгасан,
- 9 төсөл, арга хэмжээний чанарын баталгааны 5 хувийн барьцааг тооцооллын алдаанаас шалтгаалан гэрээний дүнгээс илүү тооцож, 12.4 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг төвлөрүүлсэн,
- 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гадаадын иргэн харьяатын албанд шаардлагатай тоног төхөөрөмж” худалдан авах ажлын гүйцэтгэгч Арвиндээж ХХК гэрээнд заасан хугацаанд бараа ажил үйлчилгээг хүлээлгэн өгөөгүй байхад 0.4 сая төгрөгийн алданги тооцож суутгаагүй байна.

Эдгээр нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх , 42.5, гэрээний тусгай нөхцөлийн 4.15, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 24 дүгээр зүйлийн 24.4, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**3.3.3** Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 11,505.3 сая төгрөгийн 70 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж баталснаас 7,956.9 сая төгрөгийн 55 төсөл арга хэмжээ бүрэн, 1,860.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжиж, 1,688.4 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

**3.3.4** Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг тулган баталгаажуулахад 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээний 2,624.1 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг банкны болон даатгалын

байгууллагаар баталгаажуулалгүйгээр гэрээ байгуулсан зөрчил илэрлээ. Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**3.3.5** Сумдын ОНХС, ОНХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №8. Сумдын ОНХС, ОНХО-ийн хэрэгжилт

*/сая төгрөг/*

| № | Үзүүлэлт        | ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний |                      | Бүрэн хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний |                      | Дутуу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний |                     | Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний |                     |
|---|-----------------|--|----------------------|---|----------------------|---|---------------------|---|---------------------|
|   |                 | Тоо  | Дүн                  | Тоо   | Дүн                  | Тоо   | Дүн                 | Тоо   | Дүн                 |
| 1 | Сумын ОНХС      | 316  | 23,227,355.80        | 221   | 16,132,246.20        | 22  | 2,585,621.70        | 73  | 4,554,487.90        |
| 2 | Сумын ОНХО      | 106  | 10,515,066.80        | 80  | 7,835,804.50         | 12  | 1,051,626.60        | 14  | 1,627,635.70        |
|   | <b>Нийт дүн</b> | <b>422</b>   | <b>33,742,422.60</b> | <b>301</b>                                      | <b>23,968,050.70</b> | <b>34</b>   | <b>3,637,248.30</b> | <b>87</b>   | <b>6,182,123.60</b> |

*Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоол, ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан*

**3.3.6** Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний 76.9 хувь нь буюу 16,132.2 сая төгрөгийн 221 төсөл арга хэмжээ бүрэн, 2,585.6 сая төгрөгийн 22 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна.

**3.3.7** Сумын ОНХО-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний 86.8 хувь нь буюу 7,835.8 сая төгрөгийн 80 төсөл арга хэмжээ бүрэн, 3,637.2 сая төгрөгийн 34 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна.

**3.3.8** Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. /Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитад зөрчлөөр тооцсон/ Үүнд:

- *Мандал сум нь 6 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид олгох санхүүжилтээс суутган тооцож авах ёстой чанарын баталгааны барьцааны дүнд баталгаажгаагүй магадалшгүй ажлын зардал болон гүйцэтгэгч байгууллагад олгох ёсгүй захиалагчийн хяналтын зардал, зураг төсвийн үнэ, техник, технологийн хяналт, зөвлөх үйлчилгээний зардлын санхүүжилтуудыг оруулж 35.9 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн,*
- *Баруунбүрэн сум нь 10 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан өдрөөр урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулалгүйгээр 50 хувийн урьдчилгаа санхүүжилтэд нийт 100.0 сая төгрөг олгосон,*
- *Сант сум 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулалгүйгээр 70.0 хувийн урьдчилгаа санхүүжилтэд нийт 14.0 сая төгрөг олгосон.*

**3.3.9** Тайлант онд үндэсний их баяр наадам, сум байгуулагдсаны тэгш ойг зохион байгуулах зардалд 4 сумын ОНХС-ийн нийт эх үүсвэрийн **5.5-27.4** хувийг зарцуулсан байгаа нь ОНХС-ийн үндсэн зорилго, зорилтыг алдагдуулж байна. Үүнд:

- *Шаамар сум 106.9 сая төгрөг буюу тус сангийн нийт төсвийн 27.4 хувийг,*
- *Зүүнбүрэн сум 146.7 сая төгрөг буюу тус сангийн нийт төсвийн 23.4 хувийг,*

- Мандал сум 341.5 сая төгрөг буюу тус сангийн нийт төсвийн 7.6 хувийг,
- Ерөө сум 200.0 сая төгрөг буюу тус сангийн нийт төсвийн 5.5 хувийг гэх мэт.

### **3.4 Шилэн дансны тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан уу ?**

*Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн зөрчил өмнөх оноос 4.4 дахин өссөн байна.*

**3.4.1** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор төсвийн захирагчид нь [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Дээрх үүргийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрч санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн ТЕЗ-ийн мэдээлбэл зохих 7 төрлийн 17 мэдээллийг хугацаа хоцроосон,
- 10 сумын төвлөрүүлэн захирагчид нь 207 мэдээллийг хугацаа хоцроосон бөгөөд 11 мэдээллийг огт мэдээлээгүй,
- Худалдан авах ажиллагааны газар нь 7 мэдээллийг хугацаа хоцроосон,
- Байгаль орчны газар нь 2 мэдээллийг хугацаа хоцроосон.

**3.4.2** Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй 129.2 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн нь өмнөх оноос 4.4 дахин өссөн байна. Үүнд:

- Аймгийн ЗДНХ-өөс Статистикийн хэлтсийн 100 жилийн ойн арга хэмжээнд 14.8 сая төгрөгийн, УБТЗ-ын Сүхбаатар өртөөний түүхт 75 жилийн ойн арга хэмжээнд 5.0 сая төгрөг зэрэг нийт 19.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн,
- Сүхбаатар сумын ИТХ 20.0 сая төгрөг, Сайхан сум 25.0 сая төгрөг, Түшиг сум 30.0 сая төгрөг зэрэг нийт 75.0 сая төгрөгийн видео бичлэг, контент, баримтат кино бүтээсэн,
- Сүхбаатар сумын ЗДТГ 2.5 сая төгрөг, Мандал сум 2.1 сая төгрөг, Сайхан сум 2.0 сая төгрөг, Сант сум 3.5 сая төгрөг зэрэг нийт 10.1 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан,
- Сүхбаатар сумын ИТХ 5.3 сая төгрөг, аймгийн ИТХ 1.9 сая төгрөгийн шаардлагагүй бараа материалыг нөөцөлсөн,
- Аймгийн ЗДТГ 17.1 сая төгрөгийн шагнал, бэлэг дурсгалын зүйлс олгосон, бараа материал нөөцөлсөн,

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, 15.1.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

## ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Сэлэнгэ аймгийн 2024 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийсэн аудитаар төсвийн төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой 4,535.8 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- Сэлэнгэ аймгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 428.5 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн,
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь Зүүнбүрэн, Сант сумдын малын тоо толгойн албан татварын орлого болох 229.0 мянган төгрөгийг төсвийн суурь орлогод тооцон төлөвлөсөн,
- Дээд шатны төсөвт тодотгол хийгдсэн гэх үндэслэлээр улсын төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг дагалдуулалгүйгээр буюу зайлшгүй шаардлага үүсээгүй байхад хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг аймаг 3,185.4 сая төгрөгөөр, 5 сум 692.9 сая төгрөгөөр зэрэг нийт 3,878.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийсэн.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

**Сэлэнгэ аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:**

- Аймгийн ТЕЗ нь сумдын суурь орлогод малын тоо толгойн албан татвар болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг оруулан тооцсон байна.
- Аймаг, сумдууд нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнүүдийг ОНХО болон ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.
- Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад аймаг болон зарим сумдууд хөрөнгө оруулалт, байгууллагын урсгал зардлыг нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийсэн байна.
- Тодорхой шалтгаануудын улмаас татварын ба татварын бус орлогын төлөвлөгөөг аймаг 3,947.0 сая төгрөгөөр, 6 сум нийт 3,336.0 сая төгрөгөөр тус тус тасалсан байна.
- Төсөвт байгууллагын өөрийн орлогыг аймаг, сумдын төсөвт байгууллагууд нийт 23.9 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна
- Аймаг, сумдын дүнгээр төсвийн зарлагын төлөвлөгөө 81.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.
- Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд нь батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиг, арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.
- Аймаг, сумын ОНХО болон ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс 177 төсөл, арга хэмжээ буюу 29.3 хувь нь дутуу болон огт хэрэгжээгүй байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн зөрчил өмнөх оноос 4.4 дахин өссөн байна.

## Аймгийн ТЕЗ-ийн анхааралд толилуулах нь:

Аудитаар Сэлэнгэ аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан **113,776.4** сая төгрөгийн орлого, **109,717.0** сая төгрөгийн зарлагын гүйцэтгэлийг баталгаажуулав.

### АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

#### Нэг. Аймгийн ИТХ-ын дарга Г.Бат-Орхонд

- Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй болон зураг, төсөв, тооцоо судалгаа нь урьдчилан хийгдээгүй зэрэг төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр өргөн мэдүүлснийг ИТХ-аар батлахгүй байх замаар төсвийн төлөвлөлтөд оршиж буй зөрчлийг арилгах.
- Аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд тусгагдаагүй улс төрийн намуудад санхүүжилт олгох эх үүсвэрийг орон нутгийн төсөвт тусган, төлөвлөж, батлахгүй байх.

#### Хоёр. Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж-д

- Аймгийн төсвийг бүсчилсэн хөгжлийн бодлого, жилийн хөгжлийн бодлоготой уялдуулан, холбогдох хууль эрх зүйн актад нийцүүлэн төлөвлөж, батлуулан хэрэгжилтийг ханган ажиллах.
- Төсвийн бүх шатны захирагчид, аймаг, сумдын ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх үр нөлөө бүхий арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- ОНХО болон ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн баталгааг банкны болон даатгалын байгууллагаар баталгаажуулсны үндсэн дээр гэрээ байгуулж байх.
- Дутуу хэрэгжсэн болон огт хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд дүн шинжилгээ хийж, төлөвлөсөн төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР




Ч.ЭНХТУЯА  
Б.БАТМӨНХ  
Ц.ОТГОНБАЯР

Сэлэнгэ аймгийн ИТХ-аар батлагдсан төсвийн орлого



| №   | Орлогын төрөл   | Сангийн яамнаас хянасан дүн | Аймгийн ИТХ-ын 2023.12.04 №142 | зөрүү         | Аймгийн ИТХ-ын 2024.09.23 №180 | зөрүү                              |
|-----|---|-----------------------------|--------------------------------|---------------|--------------------------------|------------------------------------|
| 1   | Аймгийн төсвийн татварын болон татварын бус орлого    | 21,509,000.00               | 29,938,900.90                  | 8,429,900.90  | 37,890,480.80                  | 1324100015 9055436<br>7,951,579.90 |
| 2   | Аймгийн төсвийн татварын орлого                       | 20,600,000.00               | 24,201,098.00                  | 3,601,098.00  | 34,422,677.90                  | 10,221,579.90                      |
| 2.1 | Аж ахуй нэгжийн орлогын албан татвар                  | 18,000,000.00               | 21,151,098.00                  | 3,151,098.00  | 29,700,000.00                  | 8,548,902.00                       |
| 2.2 | Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 800,000.00                  | 800,000.00                     | -             | 1,000,000.00                   | 200,000.00                         |
| 2.3 | Улсын тэмдэгтийн хураамж                              | 400,000.00                  | 650,000.00                     | 250,000.00    | 1,570,211.90                   | 920,211.90                         |
| 2.4 | Ус ашигласны төлбөр                                   | 1,400,000.00                | 1,600,000.00                   | 200,000.00    | 2,152,466.00                   | 552,466.00                         |
| 3   | Аймгийн төсвийн татварын бус орлого                   | 909,000.00                  | 5,737,802.90                   | 4,828,802.90  | 3,467,802.90                   | (2,270,000.00)                     |
| 3.1 | Хүү, торгуулийн орлого                                | 750,000.00                  | 1,750,000.00                   | 1,000,000.00  | 1,750,000.00                   | -                                  |
| 3.2 | Бусад орлого  | 159,000.00                  | 3,987,802.90                   | 3,828,802.90  | 1,587,802.90                   | (2,400,000.00)                     |
| 3.3 | Хөрөнгө борлуулсны орлого                             |                             |                                | -             | 130,000.00                     |                                    |
|     | Өмнөх оны татварын өр төлөгдсөн                       |                             |                                | -             |                                |                                    |
| 4   | Өөрийн орлого   | -                           | 47,000.00                      | 47,000.00     | 47,000.00                      | -                                  |
| 4.1 | Үүнээс: Аймгийн ЗДТГ                                  |                             | 45,000.00                      | 45,000.00     | 45,000.00                      | -                                  |
| 4.2 | Орон нутгийн өмчийн газар                             |                             | 2,000.00                       | 2,000.00      | 2,000.00                       | -                                  |
| 5   | Аймгийн төсвийн урьд оны үлдэгдэл                     |                             | 1,529,256.00                   | 1,529,256.00  | 16,705.90                      | (1,512,550.10)                     |
| 6   | Аймгийн ОНХС-ийн урьд оны үлдэгдэл                    |                             | 1,398,192.30                   | 1,398,192.30  | 1,376,833.80                   | (21,358.50)                        |
| 7   | Аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг              | 26,529,021.00               | 26,529,021.00                  | -             | 27,768,351.00                  | 1,239,330.00                       |
| 8   | Улсад төвлөрүүлэх орлого                              |                             |                                |               |                                |                                    |
| 9   | Сумын төсвөөс аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг | 4,392,698.00                | 7,118,421.50                   | 2,725,723.50  | 7,446,406.10                   | 327,984.60                         |
|     | Үүнд: Ерөө  |                             | 2,201,684.00                   |               | 1,413,914.00                   | (787,770.00)                       |
|     | Мандал  |                             | 1,926,048.00                   |               | 1,932,050.70                   | 6,002.70                           |
|     | Сүхбаатар   |                             | 1,299,989.50                   |               | 2,378,137.30                   | 1,078,147.80                       |
|     | Сайхан  |                             | 590,700.00                     |               | 122,304.10                     | (468,395.90)                       |
|     | Хүдэр   |                             | 1,100,000.00                   |               | 1,600,000.00                   | 500,000.00                         |
|     | Нийт орлогын дүн                                      | 52,430,719.00               | 66,560,791.70                  | 14,130,072.70 | 74,545,777.60                  | 7,984,985.90                       |

Сэлэнгэ аймгийн ИТХ-аар батлагдсан төсвийн зарлага



| №     | Орлогын төрөл   | Сангийн яамнаас хянасан дүн | Аймгийн ИТХ-ын 2023.12.04 №142 | зөрүү                | Аймгийн ИТХ-ын 2024.09.23 №180 | зөрүү                         |
|-------|---|-----------------------------|--------------------------------|----------------------|--------------------------------|-------------------------------|
| 1     | <b>Аймгийн ИТХ</b>  | <b>965,176.70</b>           | <b>1,710,968.00</b>            | <b>745,791.30</b>    | <b>1,710,968.00</b>            | <b>1,324,100.15 - 965,436</b> |
| 1.1   | Үүнээс: ИТХ   | 623,788.70                  | 1,228,968.00                   | 605,179.30           | 1,228,968.00                   | -                             |
| 1.2   | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал          | 341,388.00                  | 482,000.00                     | 140,612.00           | 482,000.00                     | -                             |
| 2     | <b>Аймгийн ЗДТГ</b>   | <b>5,666,611.80</b>         | <b>7,400,448.30</b>            | <b>1,733,836.50</b>  | <b>7,801,806.80</b>            | <b>401,358.50</b>             |
| 2.1   | Үүнээс: ЗДТГ  | 5,171,206.80                | 6,345,174.50                   | 1,173,967.70         | 6,345,174.50                   | -                             |
| 2.2   | Орон нутгийн нөөц сан   | 495,405.00                  | 1,055,273.80                   | 559,868.80           | 1,456,632.30                   | 401,358.50                    |
| 3     | <b>Орон нутгийн өмчийн газар</b>                                | <b>333,848.30</b>           | <b>333,848.30</b>              | <b>-</b>             | <b>352,064.30</b>              | <b>18,216.00</b>              |
| 4     | Худалдан авах ажиллагааны газар                                 | 22,320.00                   | 394,369.00                     | 372,049.00           | 394,369.00                     | -                             |
| 5     | <b>Байгаль орчин, аялал жуулчлалын газар</b>                    | <b>2,089,243.30</b>         | <b>3,530,161.70</b>            | <b>1,440,918.40</b>  | <b>3,517,551.30</b>            | <b>(12,610.40)</b>            |
| 4.1   | Үүнээс: БОАЖГ   | 1,529,243.30                | 2,970,161.70                   | 1,440,918.40         | 2,957,551.30                   | (12,610.40)                   |
| 4.2   | Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ                     | 560,000.00                  | 560,000.00                     | -                    | 560,000.00                     | -                             |
| 6     | <b>Санхүүгийн хяналт, аудитын алба</b>                          | <b>336,173.20</b>           | <b>456,788.10</b>              | <b>120,614.90</b>    | <b>456,788.10</b>              | <b>-</b>                      |
| 7     | Халамжийн сан   | 151,270.20                  | 151,270.20                     | -                    | 151,270.20                     | -                             |
| 8     | <b>Засаг даргын ерөнхий данс</b>                                | <b>1,012,709.80</b>         | <b>2,977,450.90</b>            | <b>1,964,741.10</b>  | <b>4,224,730.50</b>            | <b>1,247,279.60</b>           |
| 8.1   | Үүнээс: Ахмад настны хөгжил хамгаалал                           | 98,809.30                   | 82,200.00                      | (16,609.30)          | 98,809.30                      | 16,609.30                     |
| 8.2   | Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх                            |                             | 40,000.00                      | 40,000.00            | 40,000.00                      | -                             |
| 8.3   | Монголын Улаан загалмай нийгэмлэгээр гэрээгээр гүйцэтгүүлэх     |                             | 70,000.00                      | 70,000.00            | 70,000.00                      | -                             |
| 8.4   | Цөм сургийн үржлийн ажил үйлчилгээ                              |                             | 20,000.00                      | 20,000.00            | 20,000.00                      | -                             |
| 8.5   | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт              | -                           | 788,000.00                     | 788,000.00           | 1,228,000.00                   | 440,000.00                    |
| 8.6   | Ус цаг уур, орчны шинжилгээ                                     | -                           | 30,000.00                      | 30,000.00            | 30,000.00                      | -                             |
| 8.7   | Мал аж ахуйг хөгжүүлэх  | 506,421.60                  | 397,100.00                     | (109,321.60)         | 437,532.80                     | 40,432.80                     |
| 8.8   | Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх                      | 86,328.00                   | 80,000.00                      | (6,328.00)           | 159,850.00                     | 79,850.00                     |
| 8.9   | Суурин газрын усан хангамж                                      | 21,150.90                   | 21,150.90                      | -                    | 21,150.90                      | -                             |
| 8.10  | Улсын төсвийн байгууллагуудад олгох орон нутгийн нэмэгдэл       | 300,000.00                  | 1,449,000.00                   | 1,149,000.00         | 2,119,387.50                   | 670,387.50                    |
| 9     | Биеийн тамир спортын газар                                      | 847,203.00                  | 1,183,599.90                   | 336,396.90           | 1,212,699.90                   | 29,100.00                     |
| 10    | Сэлэнгийн долгио чуулга   | 336,742.60                  | 336,742.60                     | -                    | 336,742.60                     | -                             |
| 11    | Орон нутгийн судлах музей                                       | 63,343.20                   | 63,343.20                      | -                    | 63,343.20                      | -                             |
| 12    | Нийтийн номын сан   | 44,130.60                   | 44,130.60                      | -                    | 44,130.60                      | -                             |
| 13    | Сэлэнгэ аймаг дахь МСҮТ   | 181,043.60                  | 225,184.30                     | 44,140.70            | 750,647.70                     | 525,463.40                    |
| 14    | Шаамар сумын МСҮТ   | 432,386.40                  | 525,463.40                     | 93,077.00            |                                | (525,463.40)                  |
| 15    | Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг                                 |                             |                                | -                    | 1,089,338.10                   | 1,089,338.10                  |
| 16    | <b>Хөрөнгийн зардлын дээд хэмжээ</b>                            | <b>5,201,881.80</b>         | <b>6,468,331.80</b>            | <b>1,266,450.00</b>  | <b>9,213,716.50</b>            | <b>2,745,384.70</b>           |
| 16.1  | Үүнээс: Их засвар   | 3,308,551.80                | 3,308,551.80                   | -                    | 3,308,551.80                   | -                             |
| 16.2  | Орон нутгийн хөрөнгө оруулалт                                   |                             | 1,266,450.00                   | 1,266,450.00         | 4,011,834.70                   | 2,745,384.70                  |
| 16.3  | Замын сан   | 1,893,330.00                | 1,893,330.00                   | -                    | 1,893,330.00                   | -                             |
|       | <b>Аймгийн 2024 оны төсвийн жилд зарцуулах зардлын нийт дүн</b> | <b>17,684,084.50</b>        | <b>25,802,100.30</b>           | <b>8,118,015.80</b>  | <b>31,320,166.80</b>           | <b>4,428,728.40</b>           |
| 17    | <b>Аймгийн ОНХС</b>   | <b>9,632,718.40</b>         | <b>11,030,910.70</b>           | <b>1,398,192.30</b>  | <b>11,505,284.20</b>           | <b>474,373.50</b>             |
|       | Үүнд: Аймгийн ОНХС-ийн эхний үлдэгдлээс                         |                             | 1,398,192.30                   | 1,398,192.30         | 1,376,833.80                   | (21,358.50)                   |
|       | Аймгийн ОНХС-д хуваарилагдсан дүн                               | 9,632,718.40                | 9,632,718.40                   | -                    | 10,128,450.40                  | 495,732.00                    |
| 18    | <b>Аймгийн ОНХС-аас сумдад хуваарилах дүн</b>                   | <b>16,896,302.60</b>        | <b>16,896,302.60</b>           | <b>-</b>             | <b>17,639,900.60</b>           | <b>743,598.00</b>             |
| 19    | <b>Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг</b>    | <b>6,854,341.30</b>         | <b>11,468,205.90</b>           | <b>4,613,864.60</b>  | <b>11,772,444.70</b>           | <b>304,238.80</b>             |
| 19.1  | Алтанбулаг  |                             | 928,485.20                     |                      | 843,327.90                     | (85,157.30)                   |
| 19.2  | Баруунбүрэн   |                             | 1,223,200.80                   |                      | 1,225,565.10                   | 2,364.30                      |
| 19.3  | Баянгол   |                             | 302,556.90                     |                      | 301,454.60                     | (1,102.30)                    |
| 19.4  | Жавхлант  |                             | 1,096,639.10                   |                      | 1,140,103.40                   | 43,464.30                     |
| 19.5  | Зүүнбүрэн   |                             | 883,191.50                     |                      | 890,544.00                     | 7,352.50                      |
| 19.6  | Орхон   |                             | 853,818.50                     |                      | 785,497.70                     | (68,320.80)                   |
| 19.7  | Орхонтуул   |                             | 1,367,574.00                   |                      | 1,527,909.80                   | 160,335.80                    |
| 19.8  | Сант  |                             | 912,420.70                     |                      | 852,663.50                     | (59,757.20)                   |
| 19.9  | Түшиг   |                             | 1,046,863.10                   |                      | 1,184,215.60                   | 137,352.50                    |
| 19.10 | Хушаат  |                             | 1,126,970.40                   |                      | 1,091,309.50                   | (35,660.90)                   |
| 19.11 | Цагааннуур  |                             | 456,093.00                     |                      | 546,047.20                     | 89,954.20                     |
| 19.12 | Шаамар  |                             | 1,270,392.70                   |                      | 1,383,806.40                   | 113,413.70                    |
| 20    | <b>Аймгийн төсвөөс улсын төсөвт шилжүүлэх орлогын хэмжээ</b>    | <b>1,363,272.20</b>         | <b>1,363,272.20</b>            | <b>-</b>             | <b>2,307,981.30</b>            | <b>944,709.10</b>             |
|       | <b>Нийт зарлагын дүн</b>  | <b>52,430,719.00</b>        | <b>66,560,791.70</b>           | <b>14,130,072.70</b> | <b>74,545,777.60</b>           | <b>7,984,985.90</b>           |

## Сумдын тодотгосон төсөв

Хавсралт 3

/сая төгрөг/

| №  | Сумдын нэр      | Анх баталсан төсөв | Тодотгосон төсөв | Зөрүү           |
|----|-----------------|--------------------|------------------|-----------------|
| 1  | Алтанбулаг      | 2,398.50           | 2,541.80         | 143.30          |
| 2  | Баруунбүрэн     | 2,753.20           | 3,029.40         | 276.20          |
| 3  | Баянгол         | 4,579.40           | 4,624.70         | 45.30           |
| 4  | Ерөө            | 12,256.50          | 12,504.00        | 247.50          |
| 5  | Жавхлант        | 2,208.10           | 2,236.70         | 28.60           |
| 6  | Зүүнбүрэн       | 2,667.00           | 2,572.70         | (94.30)         |
| 7  | Мандал          | 14,847.10          | 15,617.90        | 770.80          |
| 8  | Орхон           | 2,010.70           | 2,064.90         | 54.20           |
| 9  | Орхонтуул       | 4,345.10           | 4,640.70         | 295.60          |
| 10 | Сайхан          | 6,838.90           | 7,852.30         | 1,013.40        |
| 11 | Сант            | 2,287.80           | 2,299.10         | 11.30           |
| 12 | Сүхбаатар       | 12,374.30          | 12,598.40        | 224.10          |
| 13 | Түшиг           | 3,579.40           | 3,612.10         | 32.70           |
| 14 | Хушаат          | 2,411.80           | 2,470.30         | 58.50           |
| 15 | Хүдэр           | 4,091.80           | 4,132.00         | 40.20           |
| 16 | Цагааннуур      | 4,555.90           | 4,590.90         | 35.00           |
| 17 | Шаамар          | 2,696.30           | 3,007.10         | 310.80          |
|    | <b>Нийт дүн</b> | <b>86,901.80</b>   | <b>90,395.00</b> | <b>3,493.20</b> |

1324100015 9055436